

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
даргын 2023 оны 98 тоот тушаалын  
6 дугаар хавсралт

Хөгжлийн төслийн төлөвлөлт, хэрэгжилт, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн, Лхагварэнцэн Сугар

2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
<p>3.1. Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төслүүдийг хэрэгжүүлэх хувилбар, хөгжүүлэлтийг хийж, бэлэн байдлыг хангуулах, хөгжлийн төсөл, хөтөлбөрийн нийгэм, эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нэгдсэн бодлого, арга хэмжээг тодорхойлох, байгууллагуудыг нэгдсэн удирдлагаар хангах, оролцоог нэмэгдүүлэх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, эдийн засгийн коридорын төслүүдийг идэвхжүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт татах, дэмжих, хамгаалах, ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;</p>							
1	Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах хүрээнд эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Хэрэгжилтийн явц /Хувь/	-	Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. /100 хувь/	Шадар сайд Х.Доржхандын 2024.10.25-ны өдрийн 09 тоот тушаалаар холбогдох яам, төрийн болон төрийн бус байгууллага, салбарын мэргэжилтэн, хөндлөнгийн судлаачдын төлөөллүүдийг оролцуулсан Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Гадаадын хөрөнгө	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

182

					<p>оруулалтын тухай хуулийн хуулийн төслийг боловсруулж, ЗГ-ын гишүүдийн саналыг тусгасан бөгөөд үзэл баримтлалыг Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Шадар сайд, Гадаад харилцааны сайд, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нар хамтран 2024 оны 12 сард баталсан. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025.04.18-ны өдрийн А/50 болон Монгол Улсын Шадар сайдын 33 дугаар хамтарсан тушаалаар "Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах" чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, 2025.05.09-ний өдөр олон нийтээр хэлэлцүүлэн, хуулийн төслийг эцэслэн боловсруулсан. Улмаар төслийг 2025.06.04-ний өдрийн ЗГ-ын</p>		
--	--	--	--	--	--	--	--

					хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу бэлтгэл ажлыг хангаж байна.		
2	"Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хэлэлцээр"-ийг шинэчлэн болон шинээр байгуулах, сайжруулах санал боловсруулна.	Төслийн тоо /Тоо/	Засгийн газрын 2019 оны 93 дугаар тогтоолоор Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн загвар хэлэлцээрийг баталсан.	"Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хэлэлцээр"-ийг шинэчлэн болон шинээр байгуулах талаар санал боловсруулсан байна. /Боловсруулсан санал 3-4/	"Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хэлэлцээр"-ийг шинэчлэн болон шинээр байгуулах, сайжруулах саналын хүрээнд Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны А/71 дүгээр тушаалаар "Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр" /BIT/-ийн төслийн асуудлаар хэлэлцээ хийх, эцэслэн тохиролцох үүрэг бүхий Ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Монгол Улсын Засгийн газар болон БНТУ-ын Засгийн газар хооронд Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрийг 1998.03.16-ны өдөр байгуулсан бөгөөд тус хэлэлцээрийг шинэчлэн байгуулах саналыг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>2021.11.15 -ны өдөр болсон Монгол, Туркийн ЗГ хоорондын хамтарсан хорооны IX хуралдаанаар шийдвэрлэсэн. Туркийн тал хэлэлцээрийн төслөө 2022 оны 02 дугаар сард ирүүлсэнд Монголын тал хариу хүргүүлж байсан. Туркийн тал Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хэлэлцээрийн загвар /Model BIT/-ыг 2024 оны 08 дугаар шинэчлэн баталсан бөгөөд 12 дугаар сард монголын талд хүргүүлэн хэлэлцээг үргэлжлүүлэх саналыг тавьсан. Тус асуудлаар ажлын хэсгийн хурлыг 2025.01.28-ны өдөр зохион байгуулж, ажлын хэсгийн гишүүдэд мэдээлэл өгсөн. Хэлэлцээрийн төслийн боломжит хувилбарыг айлын талд хүргүүлэхээр ажиллаж байна. Мөн Тайланд, Вьетнам, Энэтхэг улсуудтай хэлэлцээрийн төслийн талаар цахим уулзалт хийж, хэлэлцээг үргэлжлүүлэхээр ажиллаж байна. Казакстанаас ирүүлсэн</p>	
--	--	--	--	--	--	--

					төсөлд санал боловсруулж 2025.10.01-ний 07/2708 дугаар албан бичгээр ГХЯ-д хүргүүлсэн. ОХУ-с хоёр талт хэлэлцээрт оруулах өөрчлөлтийн асуудалд санал боловсруулж 2025.11.24-ний өдрийн 02/3166 дугаар албан бичгээр ГХЯ-д хүргүүлсэн.		
3	Гадаадын хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах арга хэмжээг зохион байгуулна.	Арга хэмжээний тоо	“Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 413 дугаар, 2023 оны 160 болон 413 дугаар тогтоол тус тус гарсан.	Хөрөнгө оруулагчийн хууль, ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах арга хэмжээг тодорхойлж, гомдол, хүсэлтийн шийдвэрлэлтэд хяналт тавьсан байна. /2 арга хэмжээ/	Эдийн засаг, хөгжлийн яаманд хөрөнгө оруулагч, олон улсын банк санхүүгийн байгууллага, Гадаад харилцааны яамнаас ирүүлсэн нийт 120 гомдлоос 47 гомдолд холбогдох асуудлыг шийдвэрлүүлэхээр Засгийн газрын хуралдаанд танилцуулж, 2022 оны 413 дугаар, 2023 оны 160 болон 413 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулж чиглэлээр ажилласан. Түүнчлэн бусад гомдлыг шийдвэрлэх хүрээнд тухайн асуудлыг хариуцсан төрийн болон орон нутгийн байгууллага, албан тушаалтнаас хариу тайлбар авах, гомдол шийдвэрлэж ажиллахыг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					даалгах, эрх бүхий байгууллагад тухай уламжилж ажилласан боловч нийт 32 гомдлыг шийдвэрлэсэн байна.		
4	Засгийн газар, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр болон цаг үеийн асуудлаар удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангана.	Тушаал, шийдвэр, Ажлын хэсгийн тоо /тоо/	-	Засгийн газар, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр байгуулсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан байна. /Ажлын хэсгийн тоо -3-аас доошгүй/	Ерөнхий сайдын "Шинэ итгэл, эрс шинэтгэл" танилцуулгын Монгол Улсад 2026-2030 онд бий болох бүтээн байгуулалтын төслүүдийн үр дүн, хөрөнгө оруулалтын мэдээллийг бэлтгэн хүргүүлсэн. ЗГҮАХ-т туссан 149 төслийг ач холбогдол, хэрэгжих боломж гэсэн үндсэн 2 шалгуур, 14 дэд шалгуураар үнэлж эрэмбэлсэн. 2025 оны 10 сарын 08-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж "Хөгжлийн төслүүдийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 122 дугаар тогтоолыг боловсруулж батлуулсан ба тус тогтоолоор 1/Тэргүүн ээлжид хэрэгжүүлэх 81 төсөл, 2/Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэх шаардлагатай 22 төсөл, 3/Бэлэн байдлыг хангах шаардлагатай 11 төслийг тодорхойлж	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>хэрэгжилтийг эрчимжүүлэх, хариуцагчийг тодорхой болгох чиглэлээр ажилласан. Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын ахалж буй Багануурын уурхайг түшиглэсэн "Нүүрс-хими, Кокс-химийн цогцолбор"-ын техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсэг, Дархан, Сэлэнгийн бүсийн "Үйлдвэр технологийн парк"-ийн хөгжлийн төлөвлөгөө, "Дархан төмөрлөгийн үйлдвэр"-ийг өргөтгөх болон Ган үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулан батлуулж, хөрөнгө оруулагч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах бэлтгэл хангах үүрэг бүхий Ажлын хэсгийн бэлтгэл ажлыг хангуулах ажлыг хангуулан ажилласан.</p>		
5	Дотоодын болон	Хэрэгжилтийн	-	Хувийн хэвшилд	2025 оны 3 дугаар сарын	1-р сар, 2-	100%

<p>гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихэд олон улсын байгууллагаас шаардах Комплайнсын шаардлагыг хангах зорилгоор "Комплайнсын менежментийн тогтолцоо ISO 37301" стандартыг хувийн хэвшилд нэвтрүүлэх чиглэлээр мэдээлэл сурталчилгаагаар хангана.</p>	<p>явц /Хувь/</p>		<p>нэвтрүүлэх чиглэлээр мэдээлэл сурталчилгаагаар хангасан байна. /100 хувь/</p>	<p>13-ны өдөр "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн форум"-ыг зохион байгуулж, дотоодын болон гадаадын хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын 200 гаруй төлөөлөл оролцлоо. Форумын үеэр төр, хувийн хэвшлийн түншлэлийн эрх зүйн орчин, бизнесийн орчны хууль, дүрэм журам, стандарт, гэрээ, хувийн хэвшлийн бодлого, ёс зүйн асуудлыг хэлэлцэв. Мөн 2025 оны 5 дугаар сарын 9-ний өдөр "Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөл"-ийг олон нийт болон оролцогч талуудтай хэлэлцэх зорилгоор ээлжит хэлэлцүүлгийг зохион байгуулж, олон улсын байгууллага, хөгжлийн түнш байгууллага, гадаад улсуудаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамд, мэргэжлийн холбоод, бизнесийн зөвлөл, танхимууд, хөрөнгө оруулагчдын төлөөлөл бүхий 130 гаруй хүн оролцсон. Хэлэлцүүлгийн үеэр Монгол Улс дахь</p>	<p>р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар</p>	
---	-------------------	--	--	--	---	--

					гадаадын хөрөнгө оруулалтын орчин, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийг нээлттэй хэлэлцэж, бизнесийн орчны хууль, дүрэм журам, стандарт, гэрээ, хувийн хэвшлийн бодлого, ёс зүйн асуудлыг хөндөн ярилцсан. Эдгээр арга хэмжээ нь олон улсын хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх, Монгол Улсад компаенсын соёлыг төлөвшүүлэх, улмаар ISO 37301 стандартыг хувийн хэвшилд нэвтрүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх юм.		
3.2. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах, хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх хувилбарыг боловсруулах, хөгжүүлэлтийг хийх, бэлэн байдлыг хангуулах, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох ажлыг зохион байгуулж нэгдсэн удирдлагаар хангах, хөрөнгө оруулалтын талаарх эрх зүйн орчин, дотоод зах зээлийн таатай нөхцөлийг боловсронгуй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.							
6	Засгийн газар, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр болон цаг үеийн асуудлаар удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангана.	Тушаал, шийдвэр, Ажлын хэсгийн тоо /тоо/	-	Засгийн газар, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр байгуулсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан байна. /Ажлын хэсгийн тоо 3-аас доошгүй/	Улсын хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем /www.invest.gov.mn/-ээр дамжуулан УХОХ-т тусгах саналыг 2025 оны 10 дугаар сарын хүртэл саналыг хүлээн авч, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах аргачлалын дагуу төслүүдийг үнэлж	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>эрэмбэлэн боловсруулсан. "Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, холбогдох хавсралтуудыг боловсруулж Бүх сайд, Улсын Их Хуралд ажаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага нараас санал авахаар Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 10 сарын 01-ний өдрийн 01/2707 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. 2025 оны 10 сарын 15-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон. Улмаар 2025 оны 10 сарын 21 өдрийн 01/2871 дугаартай албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 2025 оны 11 сарын 28-ний өдрийн Улсын Их хурлын чуулганаар хэлэлцэгдэж батлагдсан. Нийт улсын хөгжлийг</p>		
--	--	--	--	--	--	--	--

					хурдасгахад шаардагдах дэд бүтэц, нийгмийн хэрэгцээг хангах, салбарын бодлогыг эрчимжүүлэх чиглэлийн 87 төсөл батлагдсан.		
3.3. Ногоон санхүүжилтийн бодлогыг тодорхойлох, холбогдох хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, ногоон санхүүжилт татах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх, ногоон төсөл хөтөлбөрүүдийг бойжуулах, тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавина.							
7	Ногоон эдийн засаг, ногоон санхүүжилтийн нэгдсэн бодлогыг тодорхойлох, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангах арга хэмжээг уялдуулан зохион байгуулна	Боловсруулсан баримт бичиг, хүргүүлсэн саналын тоо /тоо/	"Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай анхдагч хуулийг 2025 онд өргөн мэдүүлэхээр тусгасан.	Ногоон санхүүжилтийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд холбогдох Ажлын хэсэгт орж ажиллаж, эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулсан байна. /Уур амьсгалын тухай анхдагч хуулийн төсөл-1 Холбогдох бусад эрх зүйн баримт бичигт өгсөн төслийн санал -3	Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай" Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай анхдагч хуулийг 2025 онд өргөн мэдүүлэхээр тусгасан. Хуулийн төслийг эцэслэн боловсруулж, олон нийтийн хэлэлцүүлгийг 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан. Засгийн газрын 2025 оны 07 дугаар тогтоолоор бүтэц шинэчлэн батлагдсантай холбоотойгоор ажлын хэсгийн бүрэлдэхүүний өөрчлөгдөж байгаа бөгөөд хуулийн төсөлтэй холбоотой яамны чиг үүрэгт хамаарах 2	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>асуудлаар судалгаа хийх, хамтран ажиллах талаар хөгжлийн донор байгууллагуудад хүсэлт хүргүүлсэн. Мөн холбогдох бусад эрх зүйн баримт бичигт санал өгч ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Швейцарын Холбооны Зөвлөл хоорондын хэлэлцээр"-т гарын үсэг зурах эрх олгох тухай Ерөнхий сайдын захирамжийн төсөл</li> <li>• Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Сингапур Улсын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны хэлэлцээр"-т гарын үсэг зурах эрх олгох тухай Ерөнхий сайдын захирамжийн төсөл</li> <li>• Улаанбаатар хот болон томоохон суурин газруудын агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагааны дунд хугацааны төлөвлөгөөний төсөл</li> </ul>	
--	--	--	--	--	--	--

8	<p>Нэгдэн орсон олон талт болон хоёр талт гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг хангуулах, хоёр талт болон олон талт гэрээнд нэгдэн орох асуудлыг судалж, санал боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавина.</p>	<p>Хүргүүлсэн саналын тоо /тоо/</p>	<p>Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх хамтын ажиллагааны хэлэлцээрийг БНСУ, Япон Улстай байгуулсан.</p>	<p>Парисын хэлэлцээрийн хүрээнд бусад улсуудтай хамтран хүлэмжийн хийг бууруулах чиглэлээр хоёр талт ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. /Хамтын ажиллагааны хэлэлцээр 1/</p>	<p>Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлд заасан удирдамжийн дагуу доорх санамж бичиг болон хэлэлцээрийн ажлын хэсэгт орж ажилласан. 1.Монгол Улсын ЭЗХЯ болон БОУАӨЯ, БНСУ-ы Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний яам хооронд Улаанбаатар хотын гэр хорооллын агаарын бохирдол, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн 3 талт санамж бичгийг 2025.05.29-ний өдөр байгуулсан. Тус санамж бичгийн хүрээнд "Гэр хорооллын агаарын чанарыг сайжруулах мастер төлөвлөгөө" боловсруулагдаж байна. 2.Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Сингапур Улсын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар хамтын ажиллагааны хэлэлцээрийг 2025 оны 10 дугаар 07-ний өдөр байгуулсан. 3.Монгол Улсын Засгийн газар, Швейцарын Холбооны</p>	<p>1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар</p>	<p>100%</p>
---	---	-------------------------------------	---	---	---	--	-------------

					Улсын Холбооны зөвлөл хоорондын хэлэлцээрт 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Бразил Улсын Белем хотноо байгуулагдсан.		
9	Ногоон төслийг үнэлэх, эрэмбэлэх, тодорхойлох, ногоон төслийг нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлнэ.	Боловсруулсан баримт бичиг, хүргүүлсэн саналын тоо /тоо/	-	НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгын үнэлэх аргачлалд нийцүүлэн УХОХ, ЗГҮАХ, ҮТХН-3.0-т туссан ногоон төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. /Суурь судалгааны тайлан - 1, Ногоон төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал - 1, Ногоон төслийн жагсаалт - 1/	Монгол Улсын 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хүрээнд Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төслийн жагсаалтыг боловсруулахдаа ногоон төсөл, хөтөлбөрүүдийг тусгайлан харгалзан үзэхээр шийдвэрлэсэн. Энэ нь ногоон эдийн засгийг хөгжүүлэх, төслүүдэд ногоон санхүүжилт татах боломжийг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой. Ногоон төслүүдийг эрэмбэлэхдээ 2023 онд Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам болон Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын хамтарсан тушаалаар батлагдсан "Тогтвортой хөгжлийн зориулалтын санхүүжилтийн таксономи", мөн УХОХ-ын шалгуур үзүүлэлтийн аргачлалыг ашигласан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>1.Төслийн мэдээллийн сан бүрдүүлсэн:</p> <ul style="list-style-type: none"> <li>• PIPMIS системээр УХОХ-д ирүүлсэн 122 төслийн санал</li> <li>• ЗГҮАТ-д багтсан 149 төсөл</li> <li>• Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (NDC)-т туссан 22 төслийг хамруулсан.</li> </ul> <p>2. SDG Таксономи заасан аргачлалын дагуу ангилсан:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Эдийн засгийн 101 төсөл</li> <li>• Нийгмийн 73 төсөл</li> <li>• Ногоон 43 төсөл</li> </ul> <p>Тэдгээрээс таксономийн тодорхойлолт, хүрэх түвшинд нийцсэн, бодлогын хэд хэдэн баримт бичигт туссан гэх шалгуур үзүүлэлтийн ногоон ангилалд орсон төслийг босго үзүүлэлтээр нь шүүсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Босго үзүүлэлтэд хүрсэн 32 төсөл</li> <li>• Босго үзүүлэлтэд хүрээгүй 11 төсөл</li> </ul> <p>Дээрх босго үзүүлэлтэд хүрсэн 32 төслөөс 28 төслийг нь УХОХ-т тусгуулсан. Цаашид төсөл,</p>	
--	--	--	--	--	---	--

					хөтөлбөрүүдийг илүү нарийн шинжлэх, мөн УХОХ-ын аргачлал дахь байгаль орчны нөлөөллийн үнэлгээний оноог харгалзан ногоон төслүүдийн эрэмбийг улам сайжруулах ажлыг хийхээр төлөвлөж байна.		
10	Ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх, ногоон төсөл, хөтөлбөрүүдийг нэмэгдүүлэх, ногоон санхүүжилтийн эх үүсвэр татах чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлнэ.	Хэрэгжиж эхэлсэн төслийн тоо /тоо/	-	Хамтын ажиллагааны хүрээнд ногоон эдийн засаг, ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн байна. /Хэрэгжиж эхэлсэн төсөл - 2/	Ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх, ногоон төсөл, хөтөлбөрүүдийг нэмэгдүүлэх, ногоон санхүүжилтийн эх үүсвэр татах чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлэх ажлын хүрээнд “Монгол Улсад агаарын чанарыг сайжруулах мастер төлөвлөгөө боловсруулах” төсөл судалгааны ажил хийгдэж байна. Энэхүү төсөл нь Монгол Улсын агаарын чанарыг сайжруулах болон хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгоор Бүгд Найрамдах Солонгос Улстай хамтран хэрэгжиж байгаа бөгөөд уг хамтын ажиллагаагаар дамжуулан хоёр улсын NDC (Үндэсний тодорхойлсон хувь нэмэр)-ийн зорилгод	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>хүрэх, тогтвортой агаарын бохирдлыг бууруулах тогтолцоог байгуулах, мөн олон улсын хамтын ажиллагаанд суурилсан ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлж, ногоон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд чиглэж байна. Мөн уур амьсгалын өөрчлөлтийн ил тод байдлыг сайжруулах нь (СВIT-2) төслийн хүрээнд карбон зах зээлийн бэлэн байдлыг хангуулах, ногоон дэд бүтцийн бодлогыг тодорхойлоход дэмжлэг авч ажиллаж байна.</p>		
11	<p>Засгийн газар, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр болон цаг үеийн асуудлаар удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангана</p>	<p>Тушаал, шийдвэр, Ажлын хэсгийн тоо /тоо/</p>	-	<p>Засгийн газар, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр байгуулсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан байна. /Ажлын хэсгийн тоо - 3-аас доошгүй/</p>	<p>Засгийн газар, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр болон цаг үеийн асуудлаар удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд доорх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд дэмжлэг үзүүлж ажилласан. 1.Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 41 дүгээр захирамжаар байгуулагдсан Ажлын</p>	<p>1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар</p>	100%

					<p>хэсэгт уул уурхайн экспортыг нэмэгдүүлэх хүрээнд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий дэд ажлын хэсэг 2025 оны 07 дугаар сарын 23-ний өдөр байгуулсан. Тус дэд ажлын хэсэг хуралдаж үүрэг даалгаврын хэрэгжилтээ тайлагнаж, БНХАУ-ын талтай нүүрс экспортын яриа хэлэлцээр хийх ажлыг зохион байгуулсан.</p> <p>2.Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 08 дугаар сарын 13-ний өдрийн захирамжаар Багануурын уурхайг түшиглэсэн "Нүүрс-хими, Кокс-химийн цогцолбор"-ын техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан. БНХАУ-ын SEDIN ENGINEERING компани техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж байгаа бөгөөд төслийн нэгж холбогдох санал дүгнэлтээ өгч өөрчлөлт оруулан ажиллаж байна.</p> <p>3.Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 08</p>	
--	--	--	--	--	--	--

					дугаар сарын 22-ны өдрийн "Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай" 73 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх эдийн засаг, санхүү, татварын асуудал хариуцсан дэд ажлын хэсэг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр байгуулагдсан. Тус дэд ажлын хэсгийн хурал 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдөр болж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар ярилцсан.&#039;		
--	--	--	--	--	---	--	--

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Хариуцсан чиг үүргийн хүрээнд сургалт семинар, хэлэлцүүлэгт оролцсон байх	Хариуцсан чиг үүргийн хүрээнд сургалт семинар, хэлэлцүүлэгт оролцсон байх	Хариуцсан чиг үүргийн хүрээнд сургалт семинар, хэлэлцүүлэгт оролцсон байх	Хариуцсан чиг үүргийн хүрээнд сургалт семинар, хэлэлцүүлэгт оролцсон байна. /100 хувь/	1. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бээжин, Шанкай. Цунцин хотуудад 2025 оны 06 дугаар сарын 15-аас 07 дугаар сарын 05-ны өдрүүдэд "Монгол Улсын төрийн захиргааны удирдлагын семинар" сэдвийн хүрээнд зохион байгуулагдах сургалтад	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					хамрагдсан. 2. Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны "Уур амьсгалын өөрчлөлтийн бодлогын дэмжлэг техникийн туслалцаа (ТА10011-MON)"-ны төслийн хүрээнд Азийн Гамшгийн Бэлэн Байдлын Төв (АГББТ). Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв (УАӨСХАТ) нар Эдийн засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ)-тэй хамтран "Төсвийн хөрөнгө оруулалтаар дамжуулан Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдал болон ногоон санхүүжилтийг бэхжүүлэх нь" семинарт 2025 оны 10-р сарын 20-21 өдрүүдэд.		
2	Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байх	Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байх	Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байх	Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байна. /100 хувь/	Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол оролцож хувь хүний хөгжил болон өөрийн сонирхсон чиглэлээр мэдлэг чадвараа хөгжүүлж байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

ХЯНАСАН:

Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Бат-Ирээдүй Анар /-2



Огноо: 2025.12.15

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хөгжлийн төслийн төлөвлөлт, хэрэгжилт, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн, Лхагварэнцэн Сугар /



Огноо: 2025.12.15

